

Салбарын хяналтын газар
2024 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл-ийн хувь	
					Эхний хагас жил	Сүүлийн хагас жил		Өөрийн үнэлгээ	ХШҮ
Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ									
1.1.	Урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан боловсрол, шинжлэх ухааны салбарт хамаарах зарим арга хэмжээний хэрэгжилтийг хангуулахад анхаарч ажиллах	-	Бодлогын баримт бичигт заасан шалгуур үзүүлэлтийн дагуу	-	Хяналт шалгалтын явцад урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан боловсрол, шинжлэх ухааны салбарын чиглэлээр хяналт тавьж ажилласан байна.		Дээрх зорилтын хүрээнд "ЕБС-ийн бага ангийн нэг багшид ногдох хүүхдийн тоо, суурь боловсролын хамран сургалт норматив хэмжээнд хүрсэн эсэхэд хяналт шалгалт хийх" арга хэмжээг төлөвлөн дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. - Монгол Улсын урт болон дунд	100%	100%

						богино хугацааны бодлогын баримт бичигт хяналт шалгалтын өмнөх оны хяналт шалгалтын тоон мэдээллийг харьцуулж, суурь түвшин, хүрэх түвшинг тодорхойлов. - Алсын хараа- 2050, Монгол Улсыг 2021- 2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлээс хяналт шалгалтад хамрагдах ЕБС- ийн бага ангийн нэг багшид ногдох хүүхдийн тоо, суурь боловсролын хамрагдалтыг төлөвлөгөөт шалгалтад хамрагдах 142 сургуульд шалгахаар хяналтын хуудсанд		
--	--	--	--	--	--	---	--	--

						нэмэлт өөрчлөлт оруулав. - Ерөнхий боловсрол эзэмшүүлэх үйл ажиллагааг шалгах хяналтын хуудсаар нэг бүлэгт байх хүүхдийн тоо 35-аас ихгүй байх шаардлага тавьж, хяналт шалгалт хийхэд Хэнтий аймаг болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтад хамрагдсан ерөнхий боловсролын 7 сургуульд нэг багшид ногдох хүүхдийн тоо дунджаар 28 байна. Нийслэлд шалгалтад хамрагдсан сургуулиудад нэг багшид 40 ба түүнээс дээш хүүхэд ногдож байна. Суурь боловсролын		
--	--	--	--	--	--	---	--	--

							хамрагдалт 97 хувьтай байна.		
1.1.1	ЕБС-ийн бага ангийн нэг багшид ногдох хүүхдийн тоо, суурь боловсролын хамран сургалт норматив хэмжээнд хүрсэн эсэхэд хяналт шалгалт хийх	-	Хяналт шалгалтад хамрагдсан ЕБС-ийн тоо	Хяналт шалгалтад хамрагдсан ЕБС-ийн тоо Бага ангийн нэг багшид ногдох хүүхэд хотод - 34.6, хөдөө - 28.5. Суурь боловсролын хамран сургалт - 94,9%	Хяналт шалгалтад хамрагдах ЕБС-ийн тоо - 45 Бага ангийн нэг багшид ногдох хүүхэд хотод - 34.6, хөдөө - 28.5. Суурь боловсролын хамран сургалт - 94,9%	Хяналт шалгалтад хамрагдах ЕБС-ийн тоо - 120 Бага ангийн нэг багшид ногдох хүүхэд хотод - 34.6, хөдөө - 28.5. Суурь боловсролын хамран сургалт - 94,9%	- Монгол Улсын урт болон дунд богино хугацааны бодлогын баримт бичигт хяналт шалгалтын өмнөх оны хяналт шалгалтын тоон мэдээллийг харьцуулж, суурь түвшин, хүрэх түвшинг тодорхойлов. - Алсын хараа-2050, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлээс хяналт шалгалтад хамрагдах ЕБС-ийн бага ангийн нэг багшид ногдох хүүхдийн тоо, суурь боловсролын хамрагдалтыг төлөвлөгөөт шалгалтад	100%	100%

							хамрагдах 142 сургуульд шалгахаар хяналтын хуудсанд нэмэлт өөрчлөлт оруулав. Ерөнхий боловсрол эзэмшүүлэх үйл ажиллагааг шалгах хяналтын хуудсаар нэг бүлэгт байх хүүхдийн тоо 35-аас ихгүй байх шаардлага тавьж, хяналт шалгалт хийхэд Хэнтий аймаг болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтад хамрагдсан ерөнхий боловсролын 7 сургуульд нэг багшид ногдох хүүхдийн тоо дунджаар 28 байна. Нийслэлд шалгалтад хамрагдсан сургуулиудад		
--	--	--	--	--	--	--	--	--	--

							нэг багшид 40 ба түүнээс дээш хүүхэд ногдож байна. Суурь боловсролын хамрагдалт 97 хувьтай байна.		
Гурав. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ									
3.1.	Иргэний сурч боловсрох эрх, тэгш боломж, чанартай боловсрол эзэмших, эрүүл, аюулгүй орчин нөхцөлийг хангуулах, салбарын хууль тогтоомж, түүнд нийцүүлэн баталсан нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний актын хэрэгжилтэд хяналт шалгалт хийх, эрсдэлд суурилсан хяналтын тогтолцоог бэхжүүлэх	-	-	-	-		Дээрх зорилтын хүрээнд 8 арга хэмжээг төлөвлөн, хэрэгжилтийг хангуулан ажилласан. (Биелэлтийг арга хэмжээ бүрээр оруулсан болно)	100%	50%
3.1.1	Ерөнхий боловсролын	2,107,400	Стандартын хэрэгжилтийн	ЕБС-ийн орчны стандартын	Стандартын хэрэгжилтийн	Стандартын хэрэгжилтийн	- Ерөнхий боловсролын	100%	100 %

	сургууль болон дээд боловсролын сургалтын байгууллагын сургалтын орчны стандартын хэрэгжилтэд хяналт шалгалт хийнэ.		хувь Илэрсэн зөрчлийн эзлэх хувь	хэрэгжилтийн хувь - 47.5% Нийт илэрсэн зөрчлийн эзлэх хувь - 33,4%	хувь - 25% Илэрсэн зөрчлийн эзлэх хувь - 12,5%	хувь - 52,5% Нийт илэрсэн зөрчлийн буурах хувь - 5%-иар бууруулсан байна.	сургуулийн сургалтын орчны стандартыг төлөвлөгөөт 142 сургуульд шалгахаар төлөвлөв. 2024 оны эхний хагас жилд улсын хэмжээнд 739 ерөнхий боловсролын сургуулийн эрсдэлийн үнэлгээ хийхэд 49,5 хувь нь боловсролын сургалтын байгууллагын гадаад дотоод орчны стандартын хэрэгжилт 49,5 хувьтай байна. Боловсролын чиглэлээр хийх төлөвлөгөөт шалгалт үргэлжилж байна. 2024 оны 10 дугаар сард дуусна. ЭМЯ-наас ирүүлсэн 2023 оны төлөвлөгөөт шалгалтын дүнгээр орчны		
--	--	--	---	---	---	--	---	--	--

							стандартын хэрэгжилт эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтад хамаарах асуудлаар 59 хувьтай үнэлэгдсэн байна. Одоогоор төлөвлөгөөт бус болон төлөвлөгөөт шалгалтад хамрагдсан ерөнхий боловсролын сургуулийн 26 хувь нь сургалтын орчинд тавигдах шаардлага хангаагүй, 45 хувь нь шаардлага хангасан камер, ялгаатай хэрэгцээтэй суралцагчдад зориулсан сургалтын орчин бүрдээгүй байна. - Дээд боловсролын сургалтын		
--	--	--	--	--	--	--	---	--	--

							байгууллагын сургалтын орчны стандартын нөхцөл шаардлагын хэрэгжилтэд хийх хяналт шалгалтыг БШУ-ны сайдын 2024 оны "Ажлын хэсэг байгуулах, удирдамж батлах тухай" А/50 дугаар тушаалаар батлагдсан Дээд боловсролын сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үзүүлэлтийг баталгаажуула х, дүгнэх удирдамжид заасан аргачлалын дагуу төрийн болон төрийн бус өмчийн 77 их, дээд сургуульд шалгуур үзүүлэлтэд туссан сургалтын орчны нөхцөл		
--	--	--	--	--	--	--	--	--	--

							байдлыг үнэлж, тайлан, тоон мэдээллийг нэгтгэн боловсруулж танилцуулсан.		
3.1.2	Эрсдэлийн үнэлгээ, хяналтын хуудасны бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан хөтлөх, хяналт шалгалт хэрэгжүүлэх доод шатны нэгж, улсын байцаагчийг мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган ажиллана.	-	Хяналт шалгалтын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн баяжуулалт (тоо) Мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн тоо Хамрагдсан улсын байцаагчийн тоо	Мэдээллийн сан - 0 Мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн - 5 Хамрагдсан улсын байцаагч - 60	Хяналт шалгалтын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сантай болсон байна. Мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн тоо - 3 Хамрагдсан улсын байцаагч - 40	Хяналт шалгалтын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан хөтөлсөн байна. Мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн тоо - 6 Хамрагдсан улсын байцаагч - 70	1. Нийслэл, орон нутгийн боловсролын сургалтын байгууллагуудын эрсдэлийг үнэлж, нэгдсэн мэдээллийн сан үүсгэсэн. Шалгуур үзүүлэлтийн үнэлгээгээр: - Сургуулийн өмнөх боловсролын 1309 байгууллагад эрсдэлийн үнэлгээ хийснээс 368 нь бага, 770 нь дунд, 171 нь их эрсдэлтэй; - Ерөнхий боловсролын 836 сургуульд эрсдэлийн үнэлгээ хийснээс 154 нь бага, 558 нь дунд, 124 нь их эрсдэлтэй; -	100%	100 %

							Мэргэжлийн болон техникийн боловсролын 72 байгууллагад эрсдэлийн үнэлгээ хийснээс 21 нь бага, 46 нь дунд, 5 нь их эрсдэлтэй үнэлэгдлээ. Мөн энэхүү мэдээллийг үндэслэн сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн болон техникийн боловсролын байгууллага тус бүрээр тоон үзүүлэлтийн графикийг гарган 2023-2024 оны боловсрол, шинжлэх ухааны салбарын статистик мэдээллийн номонд		
--	--	--	--	--	--	--	--	--	--

							оруулсан. 2. Хяналт шалгалтын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан буюу шилэн хяналтын цахим систем ашиглалтанд орж байгаатай холбогдуулан системд яам, нийслэл, орон нутгийн улсын байцаагч нарт эрх үүсгэн, СӨББ, ЕБС, Мэргэжлийн болон техникийн боловсрол, их, дээд сургууль, тэдгээрийн дотуур байр, шинжлэх ухааны байгууллагууды г шалгах шинэчлэгдсэн хяналтын хуудсуудыг угсарч оруулах ажлыг хийж гүйцэтгэлээ. Энэхүү хяналт шалгалтын бүртгэл, мэдээллийн		
--	--	--	--	--	--	--	--	--	--

							нэгдсэн санд төлөвлөлт, хяналт шалгалтын мэдээллийг оруулах талаар яам, нийслэл, орон нутгийн улсын байцаагчдыг сургалтад хамруулж, зөвлөгөө мэдээлэл өгч, гарын авлагыг хүргүүлсэн. Хавсралт: 2 файл		
3.1.3	Боловсролын багц хууль, түүнд нийцүүлэн гаргасан дүрэм журам, стандартын хэрэгжилтийг хангуулах, дүрэм журам, стандартыг боловсронгуй болгох санал өгнө.	-	Санал хүргүүлсэн эрх зүйн баримт бичгийн тоо	Санал хүргүүлсэн эрх зүйн баримт бичгийн тоо - 15	Санал хүргүүлсэн эрх зүйн баримт бичгийн тоо - 6	Санал хүргүүлсэн эрх зүйн баримт бичгийн тоо - 20	1. Боловсролын багц хууль, холбогдох дүрэм журам, шинээр болон шинэчлэн батлагдсантай холбогдуулан СӨББ, ЕБС, МБТБ, их, дээд сургууль, дотуур байр, шинжлэх ухааны байгууллагуудын үйл ажиллагааг шалгах нийт 7 төрлийн хяналтын	100%	90%

							хуудсыг шинэчлэн боловсруулж, нийслэл, орон нутгийн улсын байцаагчдаас санал авч, БШУ-ны сайдын 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн А/150 дугаар тушаалаар батлуулсан. Хяналтын хуудсуудыг БШУЯ-ны цахим хуудсанд байршуулж, аж ахуйн нэгж, байгууллага татан авч өөрсдийгөө үнэлэх боломжтой болгосон. 2. Монгол Улсын Шинжлэх ухаан технологийн хууль шинэчилсэн найруулга батлах гэж байгаатай холбогдуулан шинжлэх ухааны хяналтын чиглэлээр		
--	--	--	--	--	--	--	---	--	--

							нэмэлт өөрчлөлт оруулах санал хүргүүлсэн. 3. ЕБС-ийн дотуур байрны орчны стандартын хэлэлцүүлэгт орж, орон нутгийн дэмжлэг оролцоог нэмэгдүүлэх, дотуур байрын багшийг мэргэшүүлэх, тогтвор суурьшилтай ажиллахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх, багш, ажилтны ажлын байрны чиг үүрэгт хүүхэд, хөгжил хамгааллын асуудлыг тодорхой тусгах талаар санал өглөө. 4. Төрөлжсөн сургалт зохион байгуулах журам, боловсролын сургалтын байгууллагын багш болон		
--	--	--	--	--	--	--	--	--	--

							удирдах ажилтны ёс зүйн дүрэм, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2019 онд баталсан А/511 дүгээр тушаалд нэмэлт өөрчлөлт оруулах, Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын боловсрол, шинжлэх ухааны байцаагчийн албан тушаалын тодорхойлолты н төсөлд санал боловсруулж, БНБТГ-г хүргүүлсэн. 5. Дээд боловсролын сургалтын байгууллагад холбогдох цахим бүртгэлийн шинэчилсэн дүрэм, журмын төсөлд санал өгч ажиллалаа.		
--	--	--	--	--	--	--	---	--	--

							Хавсралт: 8 файл		
3.1.4	Их буюу дунд эрсдэлтэй үнэлэгдсэн боловсролын сургалтын байгууллагуудад төлөвлөгөөт шалгалт хийх	11,591,400	Шалгалт хийсэн объектын тоо Зөрчил арилгуулалтын хувь Хууль сахин мөрдөлтийн түвшин	Шалгалт хийсэн объектын тоо - 390 Зөрчил арилгуулалтын хувь - 73% Хууль сахин мөрдөлтийн түвшин - 75%	Шалгалт хийсэн объектын тоо - 150 Зөрчил арилгуулалтын хувь - 35% Хууль сахин мөрдөлтийн түвшин - 40%	Шалгалт хийсэн объектын тоо - 342 Зөрчил арилгуулалтын хувь - 83% Хууль сахин мөрдөлтийн түвшин - 85%	- 2024 онд их дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 342 объектод Эрүүл мэндийн яамны хүүхэд өсвөр үеийн эрүүл ахуйн байцаагчтай хамтарч шалгалт хийхээр 2024 оны 02 дугаар сарын 19-ны өдөр 03-00/03 дугаартай Боловсролын сургалтын байгууллагад төлөвлөгөөт хяналт шалгалт хийх" удирдамжийг Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газартай хамтран баталлаа. Удирдамжийн дагуу шалгалт хийж байна. Хяналт шалгалт 50 хувьтай байна. -	100%	90%

							Салбарын хяналтын газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 12-ны өдөр баталсан удирдамжийн дагуу Шинжлэх ухаан академийн физик технологийн хүрээлэнд 03/6.1-7 кодтой "Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас"-аар хяналт шалгалт хийлээ. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах улсын ахлах байцаагчдын хамтарсан хугацаатай албан шаардлага хүргүүлэн ажиллалаа. Гүйцэтгэлийн хяналт шалгалтыг 2024		
--	--	--	--	--	--	--	---	--	--

							оны 07 дугаар сард хийнэ. Хавсралт: 3 файл		
3.1.5	Хэнтий аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар болон их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаанд төлөвлөгөөт шалгалт хийх	11,145,000	Шалгалтад хамрагдсан байгууллагын тоо Зөрчил арилгуулалтын хувь Хууль сахин мөрдөлтийн түвшин	-	Шалгалтад хамрагдсан байгууллагын тоо - 8 Зөрчил арилгуулалтын хувь - 70% Хууль сахин мөрдөлтийн түвшин - 65%	-	Монгол улсын Засгийн газрын 2023 оны "Хяналт шалгалтын төлөвлөгөө батлах" тухай 420 дугаар тогтоол, Боловсрол, шинжлэх ухааны яамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан Салбарын улсын Ерөнхий байцаагчийн 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 03-00/20 дугаар удирдамжийн дагуу Хэнтий аймагт 2024 оны 05 дугаар сарын 24-ны өдрөөс 31-ны өдрүүдэд төлөвлөгөөт хяналт шалгалт хийлээ. Шалгалтад	100%	100%

							Хэнтий аймгийн Өндөрхаан сумын 8-р цэцэрлэг, 5-р сургууль, политехник коллеж, Норовлин, Дадал, Баян- Адарга сумын цэцэрлэг, сургуулиуд хамрагдан, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар 11 заалт бүхий хугацаатай хамтарсан албан шаардлага өгч, мэргэжил арга зүйн зөвлөгөө өглөө. Хяналт шалгалтаар Хэнтий аймгийн Хэрлэн сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуульд тус аймгийн боловсролын хяналтын улсын байцаагчийн шалгалтад мониторинг хийж, хяналт		
--	--	--	--	--	--	--	---	--	--

							шалгалт хийсэн улсын байцаагч болон сургуулийн удирдлагуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өглөө. Норовлин, Баян-Адарга сумын ерөнхий боловсролын сургууль, дотуур байранд төлөвлөгөөт шалгалт хийж, сургууль хяналтын хуудсаар хийсэн өөрийн үнэлгээг хөндлөнгийн үнэлгээтэй харьцуулж, дүгнэлээ, цаашид анхаарах асуудал болон илэрсэн зөрчил арилгуулах улсын байцаагийн хугацаатай албан шаардлага өгч, биелэлтэд хяналт тавина. Хяналт шалгалтаар		
--	--	--	--	--	--	--	--	--	--

							нийтлэг илэрсэн зөрчил сургуулийн өөрийн удирдлагын үйл ажилллагаа тогтмолжоогүй, сургууль хөгжүүлэх бодлого, төлөвлөлт, дүрэм журам боловсруулахад эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч оролцох, санал гаргах боломжгүй, сургалтын чанар, үр дүнг хэлэлцэж, үнэлэлт дүгнэлт хийгээгүй байна. Хавсралт: 2 файл		
3.1.6	Түрээсийн байртай цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх	3,000,000	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын тоо Илэрсэн зөрчил арилгуулалтын хувь	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын тоо - 133 Илэрсэн зөрчил арилгуулалтын хувь - 55,5%	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын тоо - 110 Илэрсэн зөрчил арилгуулалтын хувь - 65%	-	Түрээсийн байранд үйл ажиллагаа явуулж байгаа цэцэрлэг, сургуулиудын үйл ажиллагаанд Эрүүл мэндийн Яамны	100%	90%

	хяналт шалгалт хийх						Салбарын хяналтын газартай хамтран 2024.02.01-ний өдрийн 03/-00/02 тоот удирдамжийн дагуу шалгалт хийлээ. Шалгалтаар энэ хичээлийн жилд нийслэлд 91 байр, орон нутагт 9 аймагт 20 цэцэрлэг түрээсийн байр авч үйл ажиллагаа явуулж байгаа ба цэцэрлэгийн түрээсийн байрыг зориулалтаар нь авч үзвэл 23 буюу 23.7% нь орон сууцны, 35 буюу 35.2% нь үйлчилгээний, 33 буюу 36.3% нь сургалтын, 10 буюу 5.3% нь бусад зориулалтын, 8 нь иргэний байр, тэдгээрт нийт 367 бүлгийн 13715 суралцагч		
--	------------------------	--	--	--	--	--	--	--	--

							суралцаж байна. Мөн нийслэлд түрээсийн байртай 23 ерөнхий боловсролын сургууль шалгалтад хамрагдаж, 14 буюу 56 хувь нь номын сан, биеийн тамирын заал, гал тогоо байхгүй байна. Хяналт шалгалтаар 96 зөрчил илэрч, 65,6 хувийг арилгууллаа. Түрээслэгч байгууллага, аж ахуйн нэгжүүд стандартад нийцүүлэн орчин нөхцөлийг сайжруулах шаардлага тавихад биелүүлэхгүй байгаа зөрчлүүд илэрч байна. Цаашид зориулалтын бус байрыг сураглтын зориулалтаар		
--	--	--	--	--	--	--	--	--	--

							ашиглахад аюулгүй байдлыг хангах, мэргэжлийн байгууллагаар эрсдэлийн үнэлгээ хийлгэж байх шаардлагатай байна. Хавсралт: 1 файл		
3.1.7	МУ-ын Засгийн газрын 2023 оны 306 дугаар тогтоолын дагуу зохион байгуулалтын өөрчлөлт орж нэгдсэн политехник коллежүүдийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх	-	Хяналт шалгалт хийсэн объектын тоо Зөрчил арилгуулалтын хувь	-	Хяналт шалгалт хийсэн объектын тоо - 3 Зөрчил арилгуулалтын хувь - 20%	Хяналт шалгалт хийсэн объектын тоо - 10 Зөрчил арилгуулалтын хувь - 50%	Тус шалгалт нь Хэнтий аймгийн төлөвлөгөөт шалгалт болон их, дээд сургууль, олон улсын хөтөлбөр хэрэгжүүлэх ерөнхий боловсролын сургуулиудад төлөвлөгөөт бус шалгалт хийгдсэнтэй холбогдуулан давхацсан тул 9-11 дүгээр сард хийгдэхээр болсон. Мөн Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 306 дугаар тогтоолын хэрэгжилтийн	100%	70%

							хүрээнд зохион байгуулалтын өөрчлөлт орж буй мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагуудын зохион байгуулалт бүрэн дуусаагүй байна.		
3.1.8	Элсэлтийн ерөнхий шалгалт зохион байгуулах үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх	-	Зөрчил арилгуулалтын хувь	Зөрчил арилгуулалтын хувь - 60%	Зөрчил арилгуулалтын хувь - 65%	-	Элсэлтийн ерөнхий шалгалт 2024 оны 7 сард зохион байгуулах болсон тул урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын удирдамжийг боловсруулан батлуулах бэлтгэл ажлыг хангаж, улсын байцаагчдад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна. Улсын хэмжээнд элсэлтийн ерөнхий	100%	70%

							шалгалтыг 7 дугаар сард зохион байгуулахаар хойшлуулсан шалтгаанаар хяналт шалгалт эхлээгүй.		
3.1.1 0	Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээлэл, удирдлагаас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу төлөвлөгөөт бус шалгалт хийх	8,604,000	Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн хувь Зөрчил арилгуулалтын хувь	Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн хувь - 90% Зөрчил арилгуулалтын хувь - 95%	Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн хувь - 80% Зөрчил арилгуулалтын хувь - 40%	Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн хувь - 90% Зөрчил арилгуулалтын хувь - 70%	1. БШУ-ы сайдын 2024 оны "Дээд боловсролын сургалтын байгууллагын 2022-2023 оны хичээлийн жилийн гүйцэтгэлийн үзүүлэлтийг баталгаажуулах, дүгнэх" А/50 дугаар тушаал, БШУ-ы сайдын 2024 оны "Ажлын хэсэг байгуулах, дүгнэлт гаргах" А/212 дугаар удирдамжийн хүрээнд 1 ажлын хэсгийг ахлан, 2 ажлын хэсгийн бүрэлдэхүүнд 3 улсын ахлах байцаагч оролцож, нийт 77 дээд	100%	100 %

							боловсролын сургалтын байгууллагад төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, цаашид авах арга хэмжээний санал дүгнэлтийг танилцуулан, гүйцэтгэлийн үзүүлэлтийг холбогдох газарт хүргүүлсэн. 2. Салбарын улсын Ерөнхий байцаагчийн 2024 оны "Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай" удирдамжийн дагуу 3 ажлын хэсгийг 3 улсын ахлах байцаагч ахлан олон улсын хөтөлбөр хэрэгжүүлэх эрх бүхий 22 ерөнхий боловсролын сургуульд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийлээ.		
--	--	--	--	--	--	--	---	--	--

							Шалгалтаар олон улсын хөтөлбөр хэрэгжүүлдэг хэдий ч үндэсний хөтөлбөр хэрэгжүүлдэггүй, олон улсын хөтөлбөрийг хэрэгжүүлэх багш дутагдалтай, удирдах зөвлөлгүй зэрэг зөрчил дутагдал илэрч, илэрсэн зөрчилтэй холбогдуулан зөрчлийг арилгах талаар анхааруулан, мэргэжил арга зүйн зөвлөгөө өглөө. 3. Иргэний гомдлын дагуу 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр 03-00/46 дугаартай удирдамжаар Найтын Австрали сургуульд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж,		
--	--	--	--	--	--	--	---	--	--

							улсын бүртгэлгүй, сургалт эрхлэх түр зөвшөөрөлтэй, өөрийн байргүй зөрчлүүдэд Зөрчлийн тухай хуулийн 9.1.5 дахь заалтаар 2,0 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, илэрсэн зөрчлийг арилгуулж байна. 4. Тэмүүжин- Өрлөг сургуульд 2024 оны 05 дугаар сарын 03-00/19 удирдамжаар шалгалт хийж, 03-00-00/002/14 дугаартай албан шаардлага өглөө. Ес эрдэм/Электро н жаал/ сургуульд 03- 00/21 дугаартай удирдамжаар 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдөр, Олонлог		
--	--	--	--	--	--	--	--	--	--

							академи сургууль 2024 оны 05 дугаар сарын22-ны өдөр 03-00/22 дугаар удирдамжаар төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, хариу хүрүүлээ. Хавсралт: 5 файл		
3.2.	Шинжлэх ухааны чиглэлээр хууль, дүрэм журмын хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах, урьдчилан сэргийлэх хяналт тавих	-	-	-	-		Энэхүү зорилтын хүрээнд 3 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэн, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.	100%	90%
3.2.1	Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх шалгалт хийх	7,502,100	Шалгалтад хамрагдсан байгууллагын тоо Зөрчил арилгуулалтын хувь	-	Шалгалтад хамрагдсан байгууллагын тоо - 1 Зөрчил арилгуулалтын хувь - 30%	-	ХААИС-ийн харьяа Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай удирдамжийг	100%	70%

							боловсруулж, батлуулсан. /Салбарын улсын Ерөнхий байцаагчийн 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 03-00/14 дугаар бүхий/ Удирдамжийн дагуу хийхээр төлөвлөж байна. Тус шалгалт нь Боловсрол, шинжлэх ухааны сайдын А/50 тушаалаар байгуулсан дээд боловсролын сургалтын байгууллагын 2022-2023 оны хичээлийн жилийн гүйцэтгэлийн үзүүлэлтийг баталгаажуула х, дүгнэх чиг үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагаа 3, 4, 5 дугаар сард үргэлжлэн хийгдсэн тул тус шалгалтыг 08 дугаар		
--	--	--	--	--	--	--	--	--	--

							сарын 23-ны өдөр хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэхээр хойшлуулсан. Хавсралт: 1 файл		
3.2.2	Шинжлэх ухаан, технологи, инновацийн үр дүнг орон нутагт түгээн дэлгэрүүлэх аяныг зохион байгуулахад оролцох	-	Зохион байгуулсан аяны тоо Хамрагдсан байгууллага, хүний тоо Үр дүн	Аян зохион байгуулсан аймаг - 5	Аян зохион байгуулсан аймаг - 2	Аян зохион байгуулсан аймаг - 2	Шинжлэх ухаан, технологи, инновацын үр дүнг орон нутагт түгээн дэлгэрүүлэх аяныг 2024 оны 01 дүгээр сарын 10-11-ний өдөр Төв, 04 дүгээр сарын 09-11-ний өдөр Хэнтий, 05 дугаар сарын 02-05-ны өдөр Булган, 05 дугаар сарын 09-10-ны өдөр Сэлэнгэ аймагт тус тус зохион байгуулсан. Аяны хүрээнд Шинжлэх ухаан, технологийн талаарх төрийн бодлого төлөвлөлт, шийдвэрийг танилцуулах зорилго бүхий эрдэм	100%	100 %

							шинжилгээний хурал, шинжлэх ухааны судалгаа хөгжүүлэлтийн үр дүнд бий болсон бүтээгдэхүүн үйлчилгээний үзэсгэлэн, орон нутгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн төлөвлөгөөт болон захиалгат сургалт, төр- хувийн хэвшил- эрдэмтдийн хамтын ажилагааны санамж бичиг зурах арга хэмжээ, мөн шинэ мэдлэг, ноу-хау-г бий болгох гарааны бизнесүүдийн сургалт, “Эрдэм Хакатон” уралдаант тэмцээн зэргийг зохион байгуулсан. Эдгээр арга хэмжээнд төр, хувийн		
--	--	--	--	--	--	--	---	--	--

							хэвшлийн эрдэм шинжилгээний хүрээлэн, төвийн нийт 17 байгууллагын 40 нэр төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний танилцуулга, үзэсгэлэн гаргасан байна. Нэг аймагт дунджаар 250 гаруй төр, хувийн хэвшлийн байгууллага, судалгааны байгууллага, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл аяны арга хэмжээнд оролцсон дүн мэдээ байна. Энэхүү арга хэмжээг зохион байгуулах бэлтгэл ажилд оролцсон.		
3.2.3	Улсын төсвийн хөрөнгөөр шинжлэх ухаан, технологийн салбарт хэрэгжиж буй	-	Хяналт шалгалтад хамрагдсан судалгаа хөгжүүлэлтийн ажил /тоо/	Хяналт шалгалтад хамрагдсан судалгаа хөгжүүлэлтийн ажил /тоо/ - 5	Хяналт шалгалтад хамрагдсан судалгаа хөгжүүлэлтийн ажлын тоо 1	Хяналт шалгалтад хамрагдсан судалгаа хөгжүүлэлтийн ажил /тоо/ - 2	ШУА-ийн физик, технологийн хүрээлэнд хэрэгжиж буй суурь судалгаа,	100%	70%

	судалгаа хөгжүүлэлтийн ажлын хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт тавьж, үнэлэлт дүгнэлт гаргана.		Зөрчил арилгуулалтын хувь	Зөрчил арилгуулалтын хувь - 25%	Зөрчил арилгуулалтын хувь - 10%	Зөрчил арилгуулалтын хувь - 30%	гадаадтай хамтарсан, үндсэн чиглэлийн хүрээнд хийгдэж буй төслүүдийн хэрэгжилтийн явцад шинжилгээ хийж ажиллалаа. 2024 оны байдлаар тус хүрээлэнд суурь судалгааны төсөл 3, Гадаадтай хамтарсан 2, Судалгааны үндсэн чиглэлийн хүрээнд санхүүжилтээр 4 чиглэлийн төсөл хэрэгжиж байна. Тус хүрээлэн нь АНУ, Герман улстай хамтран хэд хэдэн төслийг амжилттай хэрэгжүүлж байгаа ба энэ хүрээнд нүүрсээр дулааны		
--	---	--	---------------------------	---------------------------------	---------------------------------	---------------------------------	---	--	--

							асуудлаа шийдвэрлэдэг байсан 3 цэцэрлэгийг дулааны хураагуураар дулааны асуудлаа зохицуулах боломжтой болгосон байна. 2024 оны эхний хагас жилийн байдлаар тус хүрээлэнгийн гадаад, дотоодын мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлсэн, илгээсэн Эрдэм шинжилгээний өгүүлэл, ишлэлийг хувилж үзэхэд дундаж нь 88 хувьтай байна. Судалгаа хөгжүүлэлтийн ажлын хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт тавьж, үнэлэлт дүгнэлт гаргах ажил үргэлжилж байна.		
--	--	--	--	--	--	--	---	--	--

							Хавсралт: 2 файл		
3.3.	Зөрчлийн хэрэг бүртгэлтэй холбоотой мэдээллийн сан бүрдүүлэх, удирдлага, арга зүйгээр ханган ажиллах	-	-	-	-		Энэхүү зорилтын хүрээнд 2 арга хэмжээг төлөвлөн хэрэгжилтийг хангуулан ажилласан. (Биелэлтийг арга хэмжээ бүрт оруулж тайлагнасан болно.)	100%	100 %
3.3.1	Зөрчлийн хэрэг бүртгэлтийн үйл ажиллагаанд хяналт тавьж, удирдлага арга зүйгээр хангах	-	Зөрчлийн тоо Торгууль шийтгэврийн барагдуулалтын хувь	Зөрчлийн тоо - 130 Торгууль шийтгэврийн барагдуулалтын хувь - 89,8%	Зөрчлийн тоо - Тухай бүр Торгууль шийтгэврийн барагдуулалтын хувь - 80%	Зөрчлийн тоо - Тухай бүр Торгууль шийтгэврийн барагдуулалтын хувь - 90%	1.Нийслэлийн боловсролын газар, аймгуудын Боловсрол, шинжлэх ухааны газрын эрх бүхий албан тушаалтнуудаа с улирал тутамд илрүүлсэн зөрчил, түүнд авсан арга хэмжээний судалгааг авч, нэгтгэх ажлыг гүйцэтгэж байна. Тайлант хугацаанд Боловсрол, шинжлэх ухааны яам-2, Нийслэлийн	100%	100 %

							боловсролын газар-53, Завхан аймаг-3, Сэлэнгэ аймаг-2, нийт 60 зөрчлийг прокурорын байгууллагад бүртгүүлэн, Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулсан. Эдгээрийн торгууль шийтгэврийн барагдуулалт 100 хувь. 2.УЕП, ХЗДХ-ийн сайдын хамтарсан тушаалаар баталсан "Эрх бүхий албан тушаалтнаас оногдуулсан торгох шийтгэлийг нэмэгдүүлж тооцох хугацаа, аргачлал", "Эрхийг хязгаарлах, эрх бүхий албан тушаалтан, шүүх болон эрх бүхий байгууллага хооронд		
--	--	--	--	--	--	--	--	--	--

							мэдээлэл солилцох журам", Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлэх гэж байгаатай холбогдуулан УЕП, НПГ-аас ирүүлсэн мэдээллийг салбарын нийт улсын байцаагчдад цахим групп болон албан тоотоор хүргүүлж, удирдлага арга зүйгээр ханган ажилласан. Энэ хүрээнд аймгуудын Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга, улсын /ахлах/ байцаагч нарт “Аргачлал журмын хэрэгжилт хангуулах тухай” 13/1523 дугаартай		
--	--	--	--	--	--	--	--	--	--

							албан тоотыг боловсруулж хүргүүлсэн. 3.Баян-Өлгий аймгийн улсын байцаагч Болатад Зөрчлийн хэргийн бүрдүүлбэр, Төв аймгийн БШУГ-ын улсын байцаагч Ө.Хишигдолгор т улсын байцаагчийн эрх хүсэхэд бүрдүүлэх материалын бүрдлүүд, зөрчлийн хэрэг үүсгэх, прокурорын байгууллагад хүргүүлэх зэрэг асуудлын талаар мэдээлэл өгч, арга зүйгээр ханган ажилласан. Хавсралт: 1 файл		
3.3.2	Боловсрол, шинжлэх ухааны салбарын зөрчлийн хэрэг	-	Зөрчлийн хэргийн тоо Мэдээллийн сангийн бүрдүүлэлт	-	Зөрчлийн хэргийн тоо - Тухай бүр Мэдээллийн сангийн	Зөрчлийн хэргийн тоо - Тухай бүр Мэдээллийн сангийн	Боловсрол, шинжлэх ухааны яамны хэмжээнд: - Улсын ахлах	100%	70%

	бүртгэлтийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх				бүрдүүлэлт 40%	бүрдүүлэлт 80%	байцаагч Д.Өнөржаргал Салбарын хяналтын газрын даргын баталсан 03- 00/16 дугаартай удирдамжийн хүрээнд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх явцдаа гадаадын хөрөнгө оруулалттай "Найтын Австрали- Монгол" ЕБС нь боловсролын стандарт /Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал, ерөнхий шаардлага MNS6782:2019/ сургалтын байгууллагад тавигдах шаардлагыг зөрчсөн, улсын комисс хүлээж аваагүй байгууламжид үйл ажиллагаа явуулсан		
--	---	--	--	--	-------------------	-------------------	--	--	--

							зөрчил илрүүлснийг зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах, шалгаж шийдвэрлэх ажиллагаанд тавьсан хяналтын бүртгэлд бүртгэн, мэдээллийг Нийслэлийн прокурорын газарт хүргүүлж ажилласан. - Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах ерөнхий боловсролын 6 дугаар сургуулийн удирдлага болон зарим багш хууль бус төлбөр хураамж авсан гэх гомдлыг Хүн, хуулийн этгээд, албан тушаалтнаас зөрчлийн		
--	--	--	--	--	--	--	---	--	--

							талаарх гомдол, мэдээлэл гаргасан үндэслэлээр "Зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах, шалгаж шийдвэрлэх ажиллагаанд тавьсан хяналтын бүртгэл"-д бүртгэв. Уг мэдээллийг Нийслэлийн прокурорын газарт хүргүүлсэн. - БШУЯ-ны ЦЦАБХГ-ын цөмийн болон цацрагийн хяналтын улсын ахлах байцаагч Н.Од- Эрдэнэ Цөмийн болон цацрагийн хяналтын улсын ерөнхий байцаагчийн баталсан 03- 01/11 дугаартай удирдамжийн хүрээнд		
--	--	--	--	--	--	--	---	--	--

						урьдчилан сэргийлэх шалгалт хийх явцдаа "Чайна энержи инженеринг групп анхуй электрик повер констракшн хоёрдугаар инженеринг" ХХК нь цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангахад тавих шаардлагыг зөрчиж, тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулсан зөрчлийг илрүүлснийг зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах, шалгаж шийдвэрлэх ажиллагаанд тавьсан хяналтын бүртгэлд бүртгэн, хуулийн хугацаанд Нийслэлийн		
--	--	--	--	--	--	--	--	--

							прокурорын газарт хүргүүлсэн. Салбарын хэмжээнд: - НБГ, аймгуудын БШУГ-ын эрх бүхий албан тушаалтнууд 58 зөрчлийг прокурорын байгууллагад бүртгүүлсэн. Хавсралт: 3 файл		
Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ									
4.1.	Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ	-	Хэрэгжүүлсэн арга хэмжээ Хэрэгжилтийн хувь	100%	100%		Тус зорилтын хүрээнд 3 арга хэмжээг төлөвлөн, хэрэгжилтийг бүрэн хангуулан ажилласан.	100%	90%
4.1.1	Цаг үеийн нөхцөл шаардлагаар хийж хэрэгжүүлэх ажил үйлчилгээг гүйцэтгэх	-	Хэрэгжүүлсэн арга хэмжээ Гүйцэтгэлийн хувь	-	Хэрэгжүүлсэн арга хэмжээ - 100 Гүйцэтгэлийн хувь - 100%	Хэрэгжүүлсэн арга хэмжээ - 100 Гүйцэтгэлийн хувь - 100%	-ХНХЯ-ны 2024 оны А/01 дүгээр тушаалаар "Монголын бурхан шашны төв гандантэгчилэн хийдийн дэргэдэх сургуульд сурч байгаа хүүхдийн эрхийн	100%	100 %

						хэрэгжилттэй танилцаж, арга зүйгээр хангах ажлын хэсэгт орж, дүнг хийдийн удирдлагад танилцуулж, шалгалтын дүнгийн тайланг ажлын хэсгийн ахлагчид өглөө. - БШУ-ны сайдын 2024 оны "Ажлын хэсэг байгуулах тухай" А/50 дугаар тушаалаар байгуулагдсан Дээд боловсролын сургалтын байгууллагын 2022-2023 оны хичээлийн жилийн гүйцэтгэлийн үзүүлэлтийг баталгаажуулах, дүгнэх ажлын хэсэгт дарга, 3 ахлах мэргэжилтэн ажиллан нийт 77 байгууллагыг шалгалаа. - БШУ-ны яамны		
--	--	--	--	--	--	--	--	--

							100 жилийн ойн хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулах комисст ажиллан, хийх ажлын төлөвлөгөө гаргаж, урилгаар оролцох хүмүүсийн нэрс, зохион байгуулалтын үйл ажиллагаа болон холбогдох гэрээнүүдийг /12 гэрээ/ хийж, арга хэмжээг 2024.02.17-ны өдөр амжилттай зохион байгуулсан. - Салбарын хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийн талаар мэдээлэл бэлтгэн гаргаж, БНБТГ-г хүргэсэн. 2023 онд төлөвлөгөөт шалгалтад хамрагдсан		
--	--	--	--	--	--	--	---	--	--

							газруудад салбарын хууль тогтоомж, дүрэм журам, стандартын хэрэгжилт нийт 66%-тай байгаа ба сургуулийн өмнөх боловсролын байгууллагад 69%, ерөнхий боловсролын сургуульд 63%, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад 64%, их, дээд сургуулиудад 68%-тай байна. - Салбарын улсын Ерөнхий байцаагчийн 2024 оны "Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай" удирдамжийн дагуу 3 ажлын хэсгийг 3 улсын ахлах байцаагч ахлан олон улсын хөтөлбөр хэрэгжүүлэх эрх бүхий 22		
--	--	--	--	--	--	--	---	--	--

							ерөнхий боловсролын сургуульд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийлээ. Шалгалтаар олон улсын хөтөлбөр хэрэгжүүлдэг хэдий ч үндэсний хөтөлбөр хэрэгжүүлдэггүй, олон улсын хөтөлбөрийг хэрэгжүүлэх багш дутагдалтай, удирдах зөвлөлгүй зэрэг зөрчил дутагдал илэрч, илэрсэн зөрчилтэй холбогдуулан зөрчлийг арилгах талаар анхааруулан, мэргэжил арга зүйн зөвлөгөө өглөө. Хавсралт: 2 файл		
4.1.3	Улсын байцаагчийн эрх олгох,	-	Эрх олгосон, цуцалсан улсын	Эрх олгосон, цуцалсан улсын	Эрх олгосон, цуцалсан улсын	Эрх олгосон, цуцалсан улсын	-Холбогдох хууль, тогтоомжийг	100%	90%

	цуцлах ажлыг хариуцан зохион байгуулж, үнэмлэх, тэмдгийн хэрэглээнд хяналт тавих		байцаагчийн тоо Хяналт тавьсан үзүүлэлт /хувь/	байцаагчийн тоо - 14 Хяналт тавьсан үзүүлэлт /хувь/ - 100%	байцаагчийн тоо - Тухай бүр Хяналт тавьсан үзүүлэлт /хувь/ - 100%	байцаагчийн тоо - Тухай бүр Хяналт тавьсан үзүүлэлт /хувь/ - 100%	үндэслэн Сүхбаатар, Увс аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын даргын албан тушаалыг хашиж байсан Л.Байгалмаа, А.Болормаа болон Төв аймгийн БШУГ-ын улсын байцаагчаар ажиллаж байсан Р.Солонго, СХГ-ын улсын ахлах байцаагчаар ажиллаж байсан М.Нямсүрэн нарын 4 ЭБАТ-ны улсын /ахлах/ байцаагчийн эрхийг цуцлах тушаалын төслийг боловсруулж, батлуулсан. - Баянхонгор аймгийн БШУГ-ын мэргэжилтэн М.Мөнхбат, Төв аймгийн БШУГ-ын улсын		
--	--	--	--	--	---	---	--	--	--

							байцаагч Ө.Хишигдолгор нарын 2 ЭБАТ-д улсын байцаагчийн эрх олгох тушаалын төслийг боловсруулж, батлуулсан. - Улсын байцаагчийн 03-16-00/035 дугаар бүхий үнэмлэх, тэмдгийг үрэгдүүлсэн тул "Хяналтын улсын байцаагчийн үнэмлэх, тэмдэг олгох, хэрэглэх, түүнд хяналт тавих журам"- ын 5.1, 5.2-т заасны дагуу уг үнэмлэх, тэмдгийг хүчингүйд тооцох тухай тушаалын төслийг боловсруулж батлуулсан. - Хас тамга үйлдвэрт захиалга өгч, 03-16-00/073 дугаар бүхий		
--	--	--	--	--	--	--	--	--	--

							тэмдгийг гаргуулан авах ажлыг зохион байгуулсан. - Засгийн газрын 2023 оны 6 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хяналтын улсын байцаагчийн үнэмлэх, тэмдэг олгох, хэрэглэх, түүнд хяналт тавих журам”-ын 3.5-д заасны дагуу Боловсрол, шинжлэх ухааны сайдын А/581 дүгээр тушаалыг үндэслэн улсын байцаагчийн 03-16-00/035 дугаартай үнэмлэх, тэмдгийг хүчингүйд тооцсон болохыг "Өглөөний сонин" сонины 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн		
--	--	--	--	--	--	--	---	--	--

							№053 /4066/ дугаарт хэвлэн нийтлүүлсэн. - Боловсрол, шинжлэх ухааны сайдын тушаалаар улсын байцаагчийн эрх олгосон Баянхонгор, Төв аймгийн БШУГ-ын улсын байцаагч М.Мөнхбат, Ө.Хишигдолгор нарт олгох үнэмлэхийг загварын дагуу хэвлүүлж, албажуулан бүртгэл хөтлөн олгосон. - Салбарын хяналтын газрын Эрх бүхий албан тушаалтнуудын тамга тэмдгийн дардсын судалгааг 2 удаа авсан. - Нийслэлийн боловсролын газрын эрх бүхий албан тушаалтнуудын тамга тэмдгийн дардсын		
--	--	--	--	--	--	--	--	--	--

							судалгааг журамд заасны дагуу мөн 2 удаа авсан. Хавсралт: 6 файл		
4.1.4	Улсын байцаагчийн үйлдсэн хяналт шалгалтын баримт бичигт нэгдсэн дугаар олгож, хяналт тавих	-	Олгосон хэвлэмэл хуудасны тоо Нэгдсэн дугаар олгосон баримт бичгийн тоо	Олгосон хэвлэмэл хуудасны тоо - 192 Нэгдсэн дугаар олгосон баримт бичгийн тоо - 55	Олгосон хэвлэмэл хуудасны тоо - Тухай бүр Нэгдсэн дугаар олгосон баримт бичгийн тоо - Тухай бүр	Олгосон хэвлэмэл хуудасны тоо - Тухай бүр Нэгдсэн дугаар олгосон баримт бичгийн тоо - Тухай бүр	Тайлант хугацаанд буюу 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн байдлаар улсын ахлах байцаагчдад - Хяналт шалгалтын удирдамжийн хэвлэмэл хуудас 30, - Хяналт шалгалтын тэмдэглэлийн хэвлэмэл хуудас 188, - Улсын ахлах байцаагчийн албан шаардлагын хэвлэмэл хуудас 53, - Хяналт шалгалтын танилцуулгын хэвлэмэл хуудас 4, - Улсын ахлах байцаагчийн акт 2, -Улсын	100%	100%

							ахлах байцаагчийн дүгнэлтийн хэвлэмэл хуудас 2, - Улсын ахлах байцаагчийн зөвлөмжийн хэвлэмэл хуудас 10, нийт 289 хэвлэмэл хуудсыг бүртгэлд аван олгосон байна. Мөн тайлант хугацаанд - Хяналт шалгалтын удирдамж 24, - Албан шаардлага 20, - Зөвлөмж 1, нийт 45 хяналт шалгалтын баримт бичгийг хянаж, нэгдсэн дугаар олгон бүртгэлжүүлсэн . Хавсралт: 1 файл		
--	--	--	--	--	--	--	---	--	--

Үнэлсэн:

.....

.....

(албан тушаал)

.....

(гарын үсэг)

/...../

.....

(огноо)

Тайлагнасан:

.....

.....

(албан тушаал)

.....

(гарын үсэг)

/...../

.....

(огноо)